

**НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 23 ДУГААР
СУРГУУЛИЙН БАГА БОЛОВСРОЛЫН БАГШ
ДОЛЖИН ОВОГТОЙ НАНЖИДЫН 2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**


I. Төлөвшил

1. Олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал
 - Хичээлийн жилийн нээлтийн үйл ажиллагаанд Багш хөгжлийн төвийн самбарыг хариуцаж шинэчилсэн.
 - Багш нарын баярыг угтсан буухиа тэмцээнд хамт олонтойгоо оролцсон.
 - Улаан-Үдэ хотод хамт олны хамтаар аялаад ирсэн аялал маш сайхан болсон.
 - Бага боловсролын багш нарын математикийн шалгалтанд хамрагдсан, үүнд хамрагдахын тулд жишиг болгон өгсөн 500 бодлогыг бодсон, маш их мэдлэгийг хуримтлуулж мартсан зүйлээ сэргээн санасан ажил болсон.
 - Голомт банкнаас зохион байгуулсан санхүүгийн боловсрол сургалтанд хамрагдаж үүнийгээ олон нийтэд түгээн дэлгэрүүлсэн байгаа.
 - Мөсөн хотхоны нээлтийн үйл ажиллагаанд оролцсон.
 - Хэлний наадмын үйл ажиллагаанд анги хамт олноо бэлтгэн оролцсон
 - Илтгэлийн уралдаанд оролцож ЧД-т 2-р байр, нийслэлд тусгай байр эзэлсэн.
 - Дүүргийн бага болосролын багш нарын дунд зохигдсон шилдэг хэрэглэгдэхүүний уралдаанд оролцож 1-р байр эзэлсэн.
 - ЧД-ийн ногоон гэрэл цагааншугам уралдаанд багаа бэлтгэн оролцож 2-р байр эзэлсэн.
 - Нийслэлийн бага боловсролын багш нарын үзүүлэх сургуульд оролцсон.
 - Шилдэг хэрэглэгдэхүүнээ өөрийн сургуулийн болон дүүрэг нийслэлэ, хөдөө орон нутгийн багш нарт ний 8 удаа түгээн дэлгэрүүлсэн байна.
2. Дэгийн хэрэгжилт, дадал хэвшил суусан байдал
 - Даасан ангийн сурагчид, эцэг эхтэй сургууль дээр мөрдөх үйл ажиллагааны дэгүүдийг нэг бүрчлэн танилцуулж ангид орж ирэхдээ Гар утсаа унтраан цүнхэндээ хийсэн байх, Багшийг орж ирэхэд хүндэтгэлтэйгээр мэндэлж хичээлээ эхэлдэг болсон. Хичээл эхлэхээс 10 минутын өмнө ирээд ангидаа байраа эзэлсэн байх, энэ дэгийг хэрэгжүүлсэнээр ангийн хоцрогдол буурч, хоцрогдолгүй хамт олон болж чадлаа.
3. Бусадтай харилцах зан чанар
 - Хичээл эхлэхэд сургалтын хэрэглэгдэхүүн бүрэн,Охид үсээ боож хэвших
 - Дүрэмт хувцасаа тогтмол өмсөх дадал хэвшүүлж байна.
 - Багшийг хичээлээ заахаар орж ирэхэд самбараа арчиж бэлдсэн байх
 - Багштай хичээлийн заахад ангиа бэлэн болж, эмх цэгцэнд ороод мэндэлдэг болсон
 - Гэрийн даалгаврыг тогтмол хийж сургасан.
 - Хичээлийн дэгийг тохиролцож сайн баримталдаг болсон
 - Багш самбарт хичээл зааж байхад өөртөө болон бусдад саад болохоо больсон. Бие биеэ хүндэлж, сонсож сурсан, Хэний зөв буруу болохыг ялгаж сурах. Бие биедээ зөв шаардлага тавьж алдааг нь хэлж өгч байх
 - Багш ажилчдыг хүндэлж харилцах
 - Найздаа тусалдаг зан чанарт нь анхаарч дэмжиж бусад сурагчид бие биедээ туслах сэтгэгдэл төрүүлдэг. Мэдсэн сурснаа бусдадаа түгээж сурах. Үр дүнтэй суралцах хамгийн сайн арга бол мэддэг зүйлээ

бусдад зааж өгөх юм гэдгийг үргэлж анхааруулдаг, сайн суръя гэвэл бусдад сайн зааж өг гэж хэвшүүлсэн

4. Сурагчдын оролцооны үр чадварын хөгжил, дадал хэвшил зан чанарын байдал
 - Даасан ангийн сурагчид Урлаг наадамд анги хамт олноороо бэлтгэн оролцож бага боловсролын анги дундаа 2-р байр эзэлсэн амжилттай байгаа.
 - Авьяаслаг 23 урлагийн наадмын Найрал дууны төрөлд 1-р байр эзэлсэн.
 - Авьяаслаг 23 урлагийн наадмын Хамтлаг хөгжмийн төрөлд 1-р байр эзэлсэн.
 - Сургуулийн хөл бөмбөгийн аьарга шалгаруулах тэмцээнд 2-р байр эзэлсэн.
 - Хэлний наадмаар Англи найрал дуу бэлтгэн амжилттай оролцож чадсан.
5. Жижүүр багшийн үнэлгээ
 - 2018.14.13-ны өдөр жижүүр багш хийн хариуцлагатай жижүүр С.Тамир менежер 30 оноо болон 100% үнэлсэн. 2018.12.11-ны өдөр жижүүр багш хийн хариуцлагатай жижүүр М.Цогзолмаа менежер 100% үнэлсэн. 2019.02.26 -ны өдөр жижүүр багш хийн хариуцлагатай жижүүр М.Цогзолмаа менежер 100% үнэлсэн. 2019.03.05-ны өдөр жижүүр багш хийн хариуцлагатай жижүүр О.Наранцэцэг номын санч 29 оноо болон 98% үнэлсэн. 2019.04.30 -ны өдөр жижүүр багш хийн хариуцлагатай жижүүр М.Цогзолмаа менежер 100% үнэлсэн. 2019.05.02-ны өдөр жижүүр багш хийн, хариуцлагатай жижүүр З.Тунгалаг менежер 100% үнэлсэн. 2018 оны 09 сар, 10 сард жижүүр багшийн үнэлгээний хуудас өгч эхлээгүй байсан тул хэдний өдөр хийснээ санахгүй байгаа. 2019 оны 01 сард сурагчдын урт амралт таарсан тул жижүүр багш хийгээгүй болно.
6. Хэдэн судалгаа хийсэн, ямар үр дүнд хүрсэн эсэх, ажилласан байдал
 - Автобус судалгаа хийж эхний байдлаар ангидаа хөршийн холбоогоор зорчих сурагчдыг тогтоож сургуульд ирэх хувийн унааны тоог багасгаж чадлаа.
 - Сурагчдаас сонирхлын судалгаа авч үүний үр дүнд хичээлээс гадуурх үйл ажиллагаа болон урлаг наадамд сурагчдаа зөв зохион байгуулан оролцож чадлаа.
 - Сурагчдаас эрсдлийн судалгаа авч эрсдэлд орж болзошгүй сурагчидтай ганцаарчлан уулзаж зөвлөгөө өглөө.
 - Анхаарлын судалгаа авч анхаарлын төвлөрөлт сарнимтгай сурагчдыг илрүүлээ.
 - Ганцаараа ирдэг сурагчдын судалгаа авч ганцаара ирэх болсон шалтгааны тодруулан аюулгүй явах талаар сануулга өгч ажиллалаа.
7. Эцэг эхийн оролцоо, хичээлээс гадуурх хүмүүжлийн ажлын үр дүн
 - Багш-эцэг эх-сурагчийн гурвалсан гэрээ байгуулсан, түүнийгээ мөрдөн ажиллаж хагас жил болон бүтэн жилээр гэрээ дүгнэж байгаа.
 - Лантуун уут ТББ-тай хамтран ажиллаж гэр хорооллын сурагчдад бэлэг өгөх үйл ажиллагаа зохион байгуулсан.
 - Эцэг эхийн зөвлөгөөнд эцэг эхийн зөвлөлийн гишүүн Энхцэцэг илтгэл тавилаа.
 - Урлаг наадам болон хэлний баярт эцэг эхийн оролцоог сайн хангаж сурагчдын хувцаслалт, дарцгаар жигдрүүлж амжилттай орлцоо.
 - Эцэг эхийн нээлттэй хаалганы өдөрлөгт эцэг эхээ бүрэн оролцуулж судалгаандп хамруулсан


- Сурагчид сургуулийн орчинд мөрдөх дэгийг хэрэгжүүлэхэд, Цахим орчинд ухаалаг соёлтой байхад, сургуулийн орчинд хориотой хоол хүнс хэрэглэхгүй хэвшихэд эцэг эхийн туслалцаа, оролцоог маш их хэмжээгээр авч үр дүнд хүрсэн амжилттай.
 - Багш эцэг эхийн дунд анги удирдах урлаг илтгэлийн үйл ажиллагаа
 - Эцэг эхийн анхдугаар зөвлөгөөн , эцэг эхчүүд илтгэл бэлтгэн бусад эцэг эхчүүд болон багш нартаа санаа бодлоо хуваалцсан үр дүнтэй ажил болсон.
 - Эцэг эхийн нээлттэй хаалганы үйл ажиллагаанд 95% ирцтэй оролцсон.
 - Мүүдл-Коха систем дээр ажиллахаар хүүхдүүд болон эцэг эхчүүдийг сургалтанд хамруулж сургасан . Эхлээд 4 эцэг эхийг дараа нь ангидаа ангийнхаа бүх эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулсан. Үүнийг мэдэж авснаар эцэг эхчүүд хүүхдийнхээ бүх мэдээллийг авч байх явдал юмаа.
 - Ангийн эрүүл аюулгүй орчны бүрдүүлэх үйл ажиллагаанд эцэг эхчүүдийн оролцоо, туслалцаа маш их би яаж туслах вэ? Гэж чин сэтгэлээсээ ханддаг.
8. Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийн биелэлт
- Сургуулийн нийгмийн ажилтан Г.Эрдэнэчимэг багштай хийсэн хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийн дагуу танхимын болон танхимын бус үйл ажиллагааг явуулсан. Мөн эцэг эхийн зүгээс анги удирдсан багштай хамтран хуваарьт ажлаа 100% биелүүлж ажиллаж чаддаг.
9. Гранд дизайны зорилго зорилтын биелэлт
- Сургуулийн гранд дизайнд бага ангийн сурагчид Зөв зан чанар зөв дадал хэвшилтэй хүүхэд байна гэж заасан байдаг. Үүнтэй уялдуулан ангидаа Амжилтын хөтөч уралдааныг зохион байгуулж зөв үйлийг хэвшүүлж чадсан бусдыгаа хошуучилсан сурагчдаа урамшууллаа.
- Мөн хичээлийн жилийн төгсгөлд ангийн сурагчдаа Бага боловсролын бүтээгдэхүүнийг шалгуурт суурилан хүлээж авах журмын дагуу шалгуураар үнэллээ.



- Хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаанд хүүхдүүдээ тэгш хамруулсан. Зөв дадал хэвшилд уриалсан санал зөвлөмжөөр зөвлөн тусалж ажилласан.. Зөв хандлагад чиглүүлсэн, сонирхол өрнөхүйц мэдээ мэдээллээр ханган ажилласан. Багаар болон бие даан асуудал шийдвэрлэх ур ухаанд чиглүүлсэн. Цагийг үр дүнтэй ,зөв хуваарьлалттай ажиллаж сурах үйл ажиллагаанд сургасан. Дугуйлан секцэд боломжоор нь хамруулах ажилд уриалсан. Үүний дүнд маш сайн хамрагдсан .ЭЭЗ-тэй хамтран хувь хүний үнэт чадварыг хөгжүүлэх, бие даан суралцах арга эзэмшүүлэх гэж хичээсэн. Өөрийн биеэр үлгэрлэн аливааг хамтран хийхийг хичээсэн.


II. Мэдлэг чадвар ахиц, амжилт

1. Гарааны болон Оношлох үнэлгээ



Түвшин	VIII		VII		VI		V		IV		III		II		I	
	Гараа	Үр дүн	Гараа	Үр дүн	Гараа	Үр дүн	Гараа	Үр дүн	Гараа	Үр дүн	Гараа	Үр дүн	Гараа	Үр дүн	Гараа	Үр дүн
Монгол хэл	4	6	7	18	14	19	14	9	8	2	5	0	2	0	2	1
Математик	20	31	8	10	17	11	4	1	2	3	4	1	3	0		
Хүн байгаль	5	21	15	13	20	14	5	5	6	4	3	0	3	0		

УЛСЫН ШАЛГАЛТ



Сурагчдын мэдлэг чадварын ахиц амжилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

МЭДЛЭГ ЧАДВАРЫН АХИЦ АМЖИЛТ	№	Үйл ажиллагаа	Үр дүн
	1.	Сурагчдын мэдлэг чадварын гарааг тогтоох	Бүх хичээлээр сурагчдын мэдлэг чадварын гарааг тогтоолоо.
	2.	Ном унших өдөр	Ангидаа ном унших өдөртэй болж сурагчид уншлагын цагаараа ном уншиж бүх сурагчид номын тэмдэглэл хөтөлж сурсан.
	3.	Илтгэл тавьж сурах	Сурагчид багаараа болон өөрийн сонирсон сэдвээр илтгэл бичиж түүнийгээ бусдад хүргэж илтгэх чадвараа хөгжүүлсэн.
	4.	Өдрийн тэмдэглэл хөтлөх	Сурагчдын зохиож найруулах чадварт ахиц гарсан.
	5.	Асуулт асуух, асуултанд оновчтой хариулах	Өөртөө итгэлтэй болж үгийн баялаг нэмгдсэн.
	6.	Ном, сэтгүүл, телевизээс хэрэгтэй мэдээллээ олж унших	Хэвлэл мэдээллээс өөрт хэрэгтэй мэдээллээ олж боловсруулалт хийх чадварт ахиц гарсан.
	7.	Шүлэг зохиох	Бүх сурагчид Миний сургууль шүлэг зохиож үзэсгэлэн гаргасан.
	8.	Кенгуру олимпиад	<ul style="list-style-type: none"> Сурагч Г.Намуундэлгэр 2-р зэрэг Сурагч О.Есүй 3-р зэрэг
	9.	Сэтгэх чадварын олимпиад	Сурагч П.Анужин ТОП үнэлгээ
10.	Бодлого бодох чадварт ахиц гарсан.	<ul style="list-style-type: none"> Хэсгийн бодлого Хөдөлгөөний бодлого Төгсгөлөөс нь бодох бодлого бодох чадварт ахиц гарсан 	

2. Улирал бүрийн нэгж хичээлийн боловсруулалт /MOODLE/ Хүн ба нийгэм болон дүрслэх урлагийн хичээлийн нэгж болон ээлжит хичээл, сорил, нэмэлт материал видео билэг оруулсан.

The image displays two screenshots from a Moodle course interface. The top screenshot shows a list of assignments with details such as the assignment name, teacher (Нанжид Должин), due date, and submission status. The bottom screenshot shows a course overview page with a navigation menu, a search bar, and several project materials including images of toy cars, a boat, and a car chassis, along with a video player and a list of related resources.

3. Өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөний биелэлт
- 23-сургуулийн шинээр хэрэгжүүлж буй Мүүдл системийг эзэмшиж сургалтандаа ашиглаж байгаа.
 - Багш бүрийн заавал унших номоос 1 ном уншиж зорилгоо биелүүлсэн.
 - Зааж буй бүлгийн Жишиг даалгаварын бодолтыг хийж хүүхдүүддээ чанартай зааж эзэмшүүлэхэд зорилгоо болгон ажиллаж 100% биелүүлсэн.
 - Залуу багш нарыг аливааг цаг хугацаанд нь бүрэн гүйцэтгэж сурахад чиглүүлэх, үлгэрлэн үзүүлэх, дагуулан сургах мөн өөрөө хамтран суралцаж зааж, заалгаж байна.

- Цэнэглэх цагт тухай бүрд хамрагдаж , сурсан мэдсэнээ амьдрал ахуйдаа үр ашигтай ашиглаж хэрэгжүүлж байгаа.
4. Судлагдахууны хөтөлбөрийн үр дүн
 - Монгол хэл,Математик, Хүн байгаль, Хүн нийгэм, Эрүүл мэнд, Иргэний боловсрол, Дүрслэх урлаг, ХГҮА –ны цаг зэрэг өөрийн заадаг хичээлийн хөтөлбөрийг цаг тухайд нь хийж батлууллаа. Үүний зэрэгцээ хичээлд хэрэглэх үзүүлэн тараах материал гарын авлагыг олон хувилбараар хийж сургалтанд ашиглаж хэвшлээ.
 - Журнал бичилт
 - Удирдсан ангийн журналаа зааврын дагуу дэлгэрэнгүй цэвэр сайхан хөтлөн.
 - Цаг тухай бүрд нь Хичээлийн үйл ажилагааг анги бүрд хэрхэн зохион байгуулсан юу нь болов, юуг анхаарах талаар дэлгэрэнгүй дүгнэлт хийсэн.
 - Багшийн тэмдэглэл хэсэгт сурагчдыг ажиллуулах арга ,заавар зөвөлгөө тэмдэглэн бичин цаг тухайд нь дүгнүүлж байсан.
 5. Хичээлд ордог сурагчдын хүртээмж

5ё ангийн 59 сурагчдад хичээл сургалтын үйл ажиллагаа явуулж байна. Хүүхдийн тоо үнэхээр стандартаас давсан нь ачаалал их болж байгаа. Цаашид хүүхдийн тоо цөөхөн бол их аятайхан гэдгийг мэдэрлээ. Гэхдээ аль болох хүүхэд нэг бүрд хүрч ажиллахын тулд долоо хоног бүр сурагч нэг бүрийн дэвтэр шалган хичээл тэмдэглэл,өөрийн үнэлгээ, хичээл дугаарлалт, гэрийн даалгавар хийснийг нэг бүрчлэн шалгаж шаардлагатай үед эцэг эхтэй холбогдож зөвлөн тусалж ажиллалаа. Үүний үр дүнд сурагчид гэрийн даалгавараа хийж хэвшиж хичээлийн тэмдэглэлээ хөтөлж сурч байдаг.Энэ нь сайн сурахын нэг гол үндэс болж өгдөг.
 6. Багшийн хөгжлийн дэвтрийн хөтлөлт
 - Багшийн хөгжлийн дэвтрийн хөтлөлт:
Багшийн хөгжлийн дэвтрийг хийж гүйцэтгэсэн ажлын дагуу өдөр тутам хөтөлж, цаашид хийх ажлаа төлөвлөн тэмдэглэн дүгнэж, байгаа.Энэ дэвтэр тайлангаа бичихэд багш хөгжлийн дэвтрээ харж байгаад бичлээ. Хийсэн ажлын өдөр хоног алдалгүй тэмдэглэх нь андуурагдахгүй маш сайн байлаа.
 - Багш хөгжлийн дэвтрийн үзүүлэлт бүрээр, өдөр тутам хийх ажил болон хийгдсэн хамрагдсан ажлаа дэлгэрэнгүй бичиж сургалтын албаар дүгнүүлж байсан.
 7. Хүүхэд бүрийн ахиц амжилтад нөлөөлсөн бүтээлч ажил
 8. Сурагчдын сурах үйлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж байгаа байдал
 - **Хөтөч төвтэй сургалт.** Багш чиглүүлж үндсэн санааг гаргуулж хичээлээ явуулснаар сурагчид хичээлээ ойлгож өөрийн өмнөх даалгавраа гүйцэтгэж багшдаа үзүүлж үнэлгээ зөвлөгөө аваад. Цааш тухайн сурагч бие биедээ зааж, багшид тусалснаар, сурагчын мэдлэг дахин нэмэгдэж, батжиж байдаг . Хэр олон найздаа тусалснаар нь багш урамшуулж нэмэлт үнэлгээ өгдөг.Энэ **Хөтөч төвтэй сургалтын** аргыг хэрэглэснээр ангийн сурагчид массаараа сайн сурах үндэс тавигдаж чаддаг гэж би бодож ажилладаг.

Ш. Авьяасыг нээн судлах хөгжүүлэх

АВЬЯАС ЫГ	1,	Бүтээлийн үзэсгэлэн	Дүрслэх урлаг технологийн хичээлээр хийсэн бүтээлээр 7 хоног бүр үзэсгэлэн гаргаж байна. Ингэснээр сурагчдын зурах, урлан бүтээх авьяас чадвар
--------------	----	---------------------	--

		хөгжиж бүтээлээ тайлбарлаж сурлаа
2.	Урлаг наадамд амжилттай оролцлоо.	2-р байр эзэлсэн.
3.	Найрал дуу	1-р байр эзэлсэн.
4.	Хамтлаг хөгжим	1-р байр эзэлсэн. 3 сурагчийг Бөмбөр дарж сургасан. 1 сурагчийг Цохилуур хөгжи дарж сургасан.
5.	Бий биелгээ	Ангийн 30 сурагч Бий биелгээ биелж сурав.
6.	Хамтлаг бүжиг	Бүжгийн хамлагтай болж хамтлагаараа Латин америк бүжиг бүжиглэ сурав.
7.	Дугуйлан секцийн судалгаа авсан.	Ангийн нийт сурагчдын 30% нь секц дугуйланд хамрагдаж байна.
8.	Ногоон гэрэл цагаан шугам	5-р ангийн 11 сурагчийг Ногоон гэрэл цагаан шугам тэмцээнд бэлдэж амжилттай оролцууллаа.
9.	Авьяасыг тандах судалгаа	Бүх сурагчдаас авьяас чадварын судалгаа авлаа.
10.	Нууцын эрэлд жүжиг үзэх	Ангиараа Хүүхэлдэй театрт Нууцын эрэлд жүжиг үзэж жүжгээс төрсөн сэтгэгдлээр Хөгжилтэй өдөр сэдэвт зохион бичлэг хийлгэлээ.

1. Ангийн номын сангийн баяжилт
 - “Сурагч бүр нэг ном” хөтөлбөрийн дагуу **БАЯЖИЛТ ХИЙСЭН** Үүнийгээ сургуулийн “Цахим номын сан”-даа бэлэг болгон өгөөд ангийн номын сандаа дахин хоёр хүүхэд нэг ном хөтөлбөрөөр баяжилт хийгдсэн.Эцэг эхчүүд хүүхдүүддээ заавал унших номыг нь авч өгч тусалж байсан..
2. Уншсан номын тэмдэглэл хөтөлсөн эсэх
Бүх сурагчид уншсан номын тэмдэглэл хөтөлж сурсан.
3. Бүтээлийн үзэсгэлэн гаргасан байдал
 - Дүрслэх урлагийн хичээлээ болон байгалийн ухааны хичээлээр хийсэн бүтээлээр бүтээлийн үзэсгэлэн гаргаж хэвшсэн.
 - Бид ирээдүй өөд хамтдаа тайлант өдөрлөгийн үйл ажиллагаанд зориулан бүтээлийн үзэсгэлэн гаргалаа.



4. Хүүхэд нэг бүрийг хөгжүүлсэн байдал /Улс нийслэл, дүүрэг, сургууль
 - Авьяаслаг 23 урлагийн наадамд 2-р байр
 - Авьяаслаг 23 урлагийн наадмын хамтлаг хөгжмийн төрөлд 1-р байр
 - Авьяаслаг 23 урлагийн наадмын найрал дууны төрөлд 1-р байр
 - Сургуулийн “Хөл бөмбөгийн “ аварга шалгаруулах тэмцээнд 2-р байр
 - Чингэлтэй дүүргийн 5-р ангиудын дунд явагдсан Математикийн хичээлийн сорилд шилдэг ангиар шалгарсан.
 - Монгол хэлний хичээлээр аав, ээж, багш сургуулийн тухай “МИНИЙ ДӨРВӨН ЭРХЭМ” шүлгийн түүвэр ном гаргасан.

7. Олимпиад уралдаан тэмцээн
 - Сурагч П.Анужин ТОП үнэлгээ

- Сурагч Бат.Хонгорзул ЧД-ийн сэтгэх чадварын олимпиадаас Хүрэл медаль
- Кенгуру олимпиадад сурагч Бат.Хонгорзул, Д.Анужин, Г.Энхсаруул,Г.Намуундэлгэр нар 2-р зэгийн диплом
- Сурагч Э.Бүжинлхам,Ц.Гэрэлт-Оюу нар 3-р зэргэийн диплом авлаа.

8. Бүтээлч ажил

- Ажил мэргэжлийн чиг баримжаа сургалтад хамрагдаж сургагч багшаар бэлтгэгдсэн .Ангийн хүүхдүүхээ Карер хөгжлийн төвийн АМЧБ сургалтанд хамруулсан байгаа.Өрийн охиноо Карер хөгжлийн төвийн судалгаа бөглүүлж үзлээ. Гарсан үр дүн нь үнэн санагдсан болно.
- 106 ангийн сурагчид өгсөн сэдвийн дагуу PPT бэлдэн цахим хэрэглэгдэхүүнтэй харьцаж бусдадаа хийсэн ажлаа маш сайн танилцуулж чаддаг болоод зогсохгүй Илтгэх чадвар нь сайжирсан байгаа. Мөн багаар мэдээлэл боловсруулж сурсан. Ангидаа болон 10-дугаар ангийн бүлгийн дунд боловсруулсан мэдээллээрээ хэлэлцүүлэг явуулж , мэдээлэл өгч хичээл зааж сурсан байгаа.

9. Хүүхэд нэг бүрийн оролцоог хангаж анги нийтээрээ хөгжсөн байдал

- Авьяаслаг 23 урлагийн наадамд 2-р байр
- Авьяаслаг 23 урлагийн наадмын хамтлаг хөгжмийн төрөлд 1-р байр
- Авьяаслаг 23 урлагийн наадмын найрал дууны төрөлд 1-р байр
- Сургуулийн “Хөл бөмбөгийн “ аварга шалгаруулах тэмцээнд 2-р байр
- Чингэлтэй дүүргийн 5-р ангиудын дунд явагдсан Математикийн хичээлийн сорилд шилдэг ангиар шалгарсан.
- Монгол хэлний хичээлээр аав, ээж, багш сургуулийн тухай “МИНИЙ ДӨРВӨН ЭРХЭМ” шүлгийн түүвэр ном гаргасан.

10. Багш ажлын байран дээрээ хөгжсөн байдал

- Мүүдл системийн сургалтыг тухай бүрд нь эзэмшиж нэг, ээлжит хөтөлбөр оруулах,эцэг эх болон сурагчдад даалгавар,мэдээлэл өгөх ,ангийн танилцуулга бичлэг хийн байршуулах, “Бар” код авах,бар кодоор мэдээлэл авах зэрэгт суралцсан.
- Цахим хэрэглэгдэхүүнтэй хичээл бэлтгэн явуулж байгаа.
- Бие бялдрын сорилд нормит үзүүлэлтийг гүйцэтгэх бэлтгэл ханган сорилыг 18 оноотой В үнэлгээтэй өгсөн
- Цэнэглэх цагаар “Луужин стратеги” 2019-10-17 сургалтад хамрагдсан.
- БМДИ газраас “Багшийн хөгжил” сургалт зохион байгуулж багш хөгжлийн дэвтэрийг хөтлөх талаар заавар зөвлөгөө өгсөн.
- Чингэлтэй дүүргийн Баатарцэнд сурагчдын автобусны судалгааг яаж бөглөх талаар сургалт зохион байгуулсан сургалтад хамрагдсан.
- Цэнэглэх цагаар “Эрүүл мэнд- гоо сайхан” сургалтад хамрагдсан
- Цэнэглэх цагаар “Эрүүл зөв дадал хэвшил ” сургалтад хамрагдсан
- Цэнэглэх цагаар “Эко-орчин ” сургалтанд хамрагдсан.
- Цэнэглэх цагаар “Авилгагүй ил тод орчин” сургалтанд хамрагдсан.
- Цэнэглэх цагаар “Банш нарын 7 дугаар их хурлын” мэдээлэлд хамрагдсан.
- Цэнэглэх цагаар “Эрүүл шүд-Эрүүл бие” сургалтанд хамрагдсан.

IV. Боловсролын сэтгэл ханамж

1. Цаг ашиглалт



- Энэ хичээлийн жилд заах ёстой хичээлийг цагийн алдагдалгүй зааж дүүргэсэн байгаа.

- Дэвтэртэй ажиллах, даалгаврыг нэг бүрчлэн шалгах
 - Журналт бичилт хийх , Багшийн хөгжлийн дэвтэр хөтлөх , Хичээл заах
 - Цаг үеийн хурал ,цуглаанд, Цэнэглэх цагт хамрагдах, Ангиа тараах , Ангиа цэвэрлүүлэх , Хяналтын ажил засах
 - Олимпиад уралдаан тэмцээнд сурагчдаа бэлтгэн явуулах, өөрөө засалтанд явах, Анги болон сурагчдаа цаг үеийн үйл ажиллагаанд бэлдэх ,Цаг үеийн сургуулийн үйл ажиллагаанд оролцох.
 - Багш нарын хичээлд суух, хамтран бэлтгэлцэх,хэлэлцүүлэх зохион байгуулах
 - Хүүхдийн сурах эрүүл ,аюулгүй орчин бүрдүүлэх.
 - Эцэг эхийн хурал зохион байгуулах, судалгаа авах .
 - Мүүдлийн сургалтанд хамрагдах , Сурагчдыг хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хамруулан үзвэр үйлчилгээ үзүүлэх,сэтгэгдэл бичүүлэх
 - Жижүүр багш хийх ,хуралд хамрагдах
 - ЗАН-ийн хурал болон цаг үеийн ажилд хамрагдах
 - Ангийн эд аж ахуйн эвдрал засах, будах шинэчлэх
 - Ангиа шалгалт шүүлэгт бэлдэх, Нэгжийн болон улирлын шалгалт авч засах дүнг оруулах, Сурагч бүрийн хувийн хэрэгтэй танилцан хөтлөлт хийх
 - Судалгаа авч нэгтгэн дүгнэлт бичих.
2. Сэтгэл ханамжийн судалгааны
- Эцэг эхээс сургуулийн үйл ажиллагааны талаар сэтгэл ханамжийн судалгаа Мүүдлээр авч бүлгээр шууд нэгтгэн дүгнэгдэж хариу гарч байсан.
 - Сурагчдаас маш олон судалгаа авч нэгтгэж дүгнэлтийг дээр судалгаа хэсэгт дэлгэрэнгүй бичиж тайлагнасан байгаа. Энэ судалгаануудыг асуулгаар болон , Мүүдл ашиглан авсан байгаа.
 - Сурагчдаас Би хэн бэ судалгаа авсан.
3. Хичээлийн цагийн хариуцлага-40 минут
- Хуваарьт хичээлээ хуваарийн дагуу цагтаа эхлүүлж эхлээд гэрийн даалгаврын шалгаж, ойлгоогүй бодлогуудыг нь хамтран ярилцаж бодож хэвшсэн байгаа.
 - Сурагч бүрийн үнэлгээ ахиц амжилтын өсөлт бууралтыг тооцон гаргаж эцэг эхчүүдэд танилцуулан сурагчтай хоёр талаас хамтран ажилласан
 - Мөн ангийн чадварт тохируулан гэрийн даалгавар өгөх, цагаа баримтлан завсарлаж хэвшсэн байгаа.
4. Багшийн ёс зүй, хууль эрх зүйн биелэлт
- Багш хүний баримтлах ёс зүй, хууль эрх зүйгээ баримтлан ажиллаж байгаа.
 - Тухайн анги ,сурагчдын нас биений онцлог зан аашны өөрчлөлтийг ШУ-ны үүднээс судалж тохирсон аргаар нь харьцан ёс зүйг дээдлэн сэтгэл ханамжтай ажиллалаа.
5. Багшийн хичээлийн бэлтгэл
- Хичээлийн цагийг баримтлан, хичээл бүрийг бэлдэн, чанартай боловсролын үйлчилгээг үзүүлэхэд анхаарч ажилласан
 - Улирал бүрийн нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулан сургалтын албаар батлуулж хичээлдээ орж байсан.
 - Мүүдл системд 3 ба 4 дүгээр улирлын 5 дугаар ангийн нэгж болон ээлжит хичээлийг байрлуулж мөн түүний дагуу шалгалт авах тестийг боловсруулан оруулсан.
 - Сэдвүүдийн дагуу даалгаврын санг бүрдүүлэн Мүүдэлд байрлуулсан.

- Боловсролын газраас жишиг болгон гаргасан “Даалгаврын санг” Мүүдэлд байрлуулж сурагчдаа тэндээс хэвлэж аван гартаа барихийг зөвлөсөн байгаа..
6. Багш сургалтын ажлын баримт бичгийг зохих журмын дагуу хөтөлж байгаа байдал
- Багшийн журналыг бүрэн бичилт хийж , Ангийн журналын үзүүлэлт бүрээр, Багшийн хөгжлийн дэвтрийг өдөр тутам хөтлөн , Сурагчийн хувийн хэргийн зөв хөтлөлтийг шалган дутууг гүйцээх зэргийг заагдсан хугацаа бүрд нь сургалтын албаар үнэлүүлж хэвшсэн.
7. Сургалтын техник хэрэгслийг ашигласан байдал
- Мүүдл системийн сургалтыг тухай бүрд нь эзэмшиж нэг, ээлжит хөтөлбөр оруулах,эцэг эх болон сурагчдад даалгавар,мэдээлэл өгөх ,ангийн танилцуулга бичлэг хийн байршуулах, “Бар” код авах,бар кодоор мэдээлэл авах зэрэгт суралцсан.
 - Цахим хэрэглэгдэхүүнтэй хичээл бэлтгэн явуулж байгаа.
 - Ангийн зурагтыг HDM оролтоор холбон “Мүүдэл”-ээс хэрэгтэй материалаа татан “Цахим” орчин үүсгэн хэрэглэж сурсан.
 - Мүүдл системд 3 ба 4 дүгээр улиралын 5дугаар ангийн нэгж болон ээлжит хичээлийг байрлуулж мөн түүний дагуу шалгалт авах тестийг боловсруулан оруулсан.
 - Сэдвүүдийн дагуу даалгаварын санг бүрдүүлэн Мүүдэлд байрлуулсан.
 - Боловсролын газраас жишиг болгон гаргасан “Даалгаварын санг” Мүүдэлд байрлуулж сурагчдаа тэндээс хэвлэж аван гартаа барихийг зөвлөсөн байгаа.
 - Амралтын даалгавар боловсруулан Мүүдэлд байрлуулан урт хугацааны амралтаараа хийж ирэхийг хэлээд түүнийгээ шалгаж үнэлсэн байгаа.
 - Өөрийн нөөтбүүк дээр шаардлагатай программ ашиглан боловсруулалт хийж сурсан.
8. Сурагчдын хөгжил төлөвшил эрсдэлийн судалгааны сан бүрдэлт

СУРАГЧДААС АВСАН ЭРСДЛИЙН СУДАЛГАА





9. Хяналтын хуудасны хэрэгжилтэнд хяналт шинжилгээ хийсэн байдал
- Аливаа үйл ажиллагаа болгоны араас ямар хэмжээнд оролцов? үйл ажиллагааг бүрэн дуусгаж чадсан уу? ,юуг дутуу хийв? ,яаж хэрхэн хэнд хүргэх асуултыг өөртөө тавьж дүгнэж сурчээ.

V. Эрүүл мэнд

1. Мэндлэх хүндлэх –Зөв боловсон харилцаа
 - Сурагчдын эрүүл харилцаа бий болгох
 - Багш сурагчдын эрүүл зөв харилцаах эрхэмлэн ажиллаж байгаа
 - Шаардлагыг сурагчидтай зөвшилцөж шийдвэрлээд дараа нь тэр шаардлагаа зөв тавих...
 - Багш өөрөө сурагчийн нэр хүндийг хүндэтгэн харьцаж тэдэнтэй эелдэг уур амьсгал бий болгох арга чадварт суралцаж ажилласан
 - Өөрийн суудаг орчинг хариуцан цэвэр орчинд хичээлэлхийн тулд сурагч бүр сэтгэлтэй байх хэрэгтэйг анхааруулдаг.
2. Эрүүл мэндийн анхан шатны дадал хэвшилд сургаж үлгэрлэсэн байдал
 - Дөрөв дүгээр цагийн завсарлагаанаар хичээл орж буй ангитайгаа Гимнастик хийж хэвшсэн.
 - Зөв суух дадалд ангийн сурагчдыг зөв суухын ашиг тусыг Шинжлжх ухааны үндсийг таниулан зөвлөн хичээл бүр дээр сануулан ажиллаж байна.
 - Ангийн сурагчдыг улирал бүр салаа хооронд байрлалыг солих, өдөр бүр урагш ахих замаар байрыг солин харааны нэг өнцөг тогтохоос сэргийлэн ажиллаж байна.
 - Хичээлийн явцад сурагчид ядарсан, хичээлийн идэвхий буурсан үед эрүүл мэндэд хэрэгтэй, дасгал хөдөлгөөн хийлгэдэг
 - Эрүүл мэндэд хэрэгтэй алга ташилт, Нүдний дасгал, Толгой сэргээх дасгал...
 - Хичээлд ирц, дүрэмт хувцас, хичээлд үс боох, бохь захлахгүй байх шаардлагуудыг ямагт тавин ажилладаг.
3. Эрүүл мэндийн сургалт зохион байгуулж гарсан үр дүн

- Ангийн бүх сурагчдыг улаан бурхнаас урьдчилан сэргийлэх вакцинд хамруулсан.
 - Эцэг эхийн зөлөлтэй хамтран “Эрүүл шүд- Эрүүл бие” сургалт зохион байгуулж сурагч бүрд шүдний үзлэг оношилгоо өгч картаар дамжуулан зөвлөгөө өгсөн.
 - Сурагчид Томуу томуу төст өвчнөөс урьчилан сэргийлэх мэдээлэл цуглуулан илтгэл бичиж мэдээллээ солилцлоо.
 - Ангийн сурагчдыг өндөр жингийн үзлэгт хамруулав.
4. Анги танхимын цэвэр эмх цэгцтэй байдалд сургаж хэвшүүлсэн байдал
 - Жижүүр сурагчид өдөр бүр ангиа цэвэрлэн хүлээлгэж өгч хэвшсэн.
 - Сурагч өөрийн сууж буй орчинг цэвэр цэмцгэр байлгаж сурсан.
 - Хичээл орж байгаа ангидаа тогтмол самбарын алчуур норгож самбар цэвэрлэсэн байхыг хэлж хэвшүүлсэн байгаа.
 5. Эрүүл орчинд байхын ач тусын талаар ойлголт өгч хэвшил болохуйц ажил зохион байгуулж үр дүнд хүрсэн байдал
 - Агаар дуслын замаар халдварлаж болох өвчний талаар “Сүрьеэ” өвчний талаар РРТ бэлдүүлэн ангид мэдээлэл хүргэн хэрхэн өөрсдийгөө эрүүл авч явах талаар ойлголттой болсон.
 - Их завсарлагаанаар үдийн цайны өмнө гараа тогтмол ариутгаж угааж хэвших.
 - Эцэг эхчүүд анги угаах материал бэлдэж өгч хэвшсэн үүнийг ангийн сурагч Ариун цэврийн дарга хариуцан ажилладаг.
 - Агаар цэвэршүүлэгчийг тогтмол ажиллах горимын дагуу хариуцан ажиллуулж хэвшиж байгаа.
 6. Жижүүр сурагчдын үйл ажиллагаа жигд ажиллагаатай эсэх
 - Даасан ангиа жижүүр сурагчид өдөр бүр хариуцлагатай цэвэрлэдэг. Долоо хоногийн 5 дахь өдөр бүр ангидаа их цэвэрлэгээ хийж хэвшсэн байгаа.
 - Сурагч өөрийн сууж буй орчинг цэвэр цэмцгэр байлгаж сурсан.
 - Анги цэвэрлэх маериал нь хүүхдийн аюулгүй байдалд нийцүүлэн бүрэн болгосон.
 - Сар бүр “Их цэвэрлэгээ” хийж гол нь ширээ сандлын хөлөнд наалдсан хир буртгийг цэвэрлүүлж, шалан дээр наалдсан бохийг хусаж арилгаж хэвшсэн.
 7. Анги танхимын эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтын талаар зөв ойлголт өгч, тэдгээртэй зөв харилцах дадал хэвшилд сургасан байдал
 - Эцэг эхийн зөвлөлтэй хамтран эд аж ахуйн эвдрэлийг тухай бүрд нь засах баг болон ажиллаж хэрэгтэй эрэг ,боолт, бахь отвертгийг ангидаа / эцэг эхээр бэлдүүлэн / бэлэн байлган ажиллаж байна.
 8. Эрүүл мэндийн үзлэг, сургалт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар хийж хэрэгжүүлсэн байдал.
 - Дэлхийн гар угаах өдрөөр эрүүл ахуйч Буянхишиг гараа хэрхэн зөв угаах талаар сургалт явууллаа.
 - “Улаан бурхан” вакцинд ангийн бүх сурагчид хамрагдсан
 - Вирусын гаралтай ханиаднаас сэргийлэх санамж зөвөлгөөг эмч И.Соёлмаагийн бэлдсэн материалаар өгсөн.
 - Өндөр жингийн индексийг гарган зөв хоололтын РРТ танилцууланв.
 9. Ангийн ариун цэвэр эрүүл мэндийн булангийн хэрэгжилт
 - Ангийн ариун цэврийн дарга М.Яна хариуцан ажиллаж ханын шүүгээнд ширээний болон шалны хувин,ширээ ханын болон шалны алчуурыг тусад нь угааж дэлгэн хатааж хадгалдаг болсон . Мөн угаалгын нунтаг, резинэн бээлийн 10ш ,ширээ болон шал угаах щётка 10ш ,гарын шингэн саван,гар ариутгах Санитол, цонх шил арчих элгэн алчуур 2ш,шил угаах цацагч

шингэн зэрэг материалыг эцэг эхчүүдээр шийдүүлэн ангийн урд буланд жижг тавиур хийлгэн байрлуулж хэрэглэж заншсан.

- Эрүүл мэндийн буланг сурагч М.Хулан хариуцан ажиллаж мэдээ, мэдээлэл, материалаа байрлуулж сольж мэдээлэл гаргадаг.Өнгө үзэмж чанарын шаалдлага хангаж байх тал дээр анхааран ажилладаг.

10. Эрүүл шүд-Эрүүл хүүхэд үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд хийсэн ажил

- Эцэг эхийн зөвлөлтэй хамран шүдний эмчийн үзлэт харуулан сурагч бүрд карт нээж өгсөн.
- Шүдний эмчийн зөвлөсний дагуу ангийн сурагчдын 60% шүдний эмнэлэгт хандаж үйлчилгээ авсан тооцоотой байна. Эцэг эхчүүд нэг үеэ бодоход хүүхдийнхээ шүд, эрүүл мэнд, гоо сайханд илүү анхаардаг болсон байна.

Ерөнхийлөгчийн санаачлагаар БСШУЯ,НБГ, Замын цагдаа, Түргэн тусламж, Онцгой байдлын алба хамтарч сурагчдад замын хөдөлгөөний дүрмийг бодит байдлаар үзүүлсэн үзүүлэх сургуульд оролцлоо.







Сургуулийн номын сангийн үйл ажиллагаатай танилцав.

**Хүн байгалийн хичээлээр Эх дэлхийгээ судалцаага
сэдвээр илтгэл тавилаа.**



Тайлан бичсэн бага боловсролын багш Д.Нанжид